

МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. УДИРТГАЛ

Хууль тогтоомж нь дангаар, бие даасан шинжтэй гэхээс илүү тодорхой эрх зүйн системийн нэг бүрэлдэхүүн болохын хувьд бусад хууль тогтоомжтой харилцан уялдаатай. Иймд тодорхой хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа түүнтэй хамааралтай хууль тогтоомжийн өөрчлөлтийг мөн боловсруулж батлах, түүнчлэн хэд хэдэн бие даасан хууль тогтоомж хамт батлагдсанаар эрх зүйн үр нөлөө нь бүрэн хэрэгжихээр байвал уялдаатай хууль тогтоомжуудыг хамтад боловсруулж батлах практик шаардлага тус тус үүсдэг.

Хэдийгээр ийнхүү хууль тогтоомжуудыг хамааралтай, уялдаатай байдлаар нь хамт боловсруулан батлах нь тодорхой бөгөөд энгийн ойлголт мэт боловч тавигдах шаардлагуудыг тогтоох, дагалдан батлагдаж буй хууль тогтоомжид судалгаа шинжилгээ хийх эсэх, олон нийтээр хэлэлцүүлэх эсэх асуудлыг тодорхой зохицуулаагүй нөхцөлд тодорхой хуулийн халхавч дор тухайн хууль тогтоомжтой төдийлөн хамааралгүй хууль тогтоомжууд судалгаа шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлгээс ангид батлагдах боломж, эрсдэлийг дагуулна.

Энэ үзэгдэл сүүлийн жилүүдийн төсвийн тухай хууль батлах явцад илэрхий ажиглагдсан нь судлаачид¹ болон олон нийтийн шүүмжлэлийг дагуулах болсон. Тухайлбал, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т төсвийн тухай хуультай нэг цаглабарын дагуу боловсруулж батлах хууль тогтоомжуудаас гадна 2021 оны төсвийн тухай хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдан 17, 2022 оны төсвийн тухай хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг дагалдан 48, 2023 оны төсвийн тухай хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдан 125, 2024 оны төсвийн тухай хуулийг дагалдан 29, 2025 оны төсвийн тухайн хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдан 19 хууль тогтоомж тус тус батлагдаж байв (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-6-аас үзнэ үү).

¹ Нээлттэй Нийгэм Форум, “Дагалдах хууль, түүнд тавигдах шаардлага: Төсвийн тухай хуулийн дагалдах хуулиудад хийсэн дүн шинжилгээ”, ННФ Бодлогын асуудал Дугаар 40, 1 дэх тал. https://forum.mn/uploads/users/3092/files/OSF_Bodlogiin%20asuudal_40.pdf

Хууль тогтоомжийн тухай хууль (ХТХ)-д дагалдах болон хамт өргөн мэдүүлэх хууль тогтоомжид тавигдах агуулгын шаардлага, дагалдах болон хамт өргөн мэдүүлэх хууль тогтоомжид ХТХ-д заасан судалгаа шинжилгээ хийх эсэх, түүнчлэн тэдгээрийг олон нийтээр хэлэлцүүлэх эсэх зэрэг асуудал тодорхойгүйгээс ХТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.3-т дагалдах хууль тогтоомж нь хэлбэрийн хувьд (i) нэмэлт, өөрчлөлт оруулах, (ii) хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль байх ёстой байтал 2022 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Төрийн хэмнэлтийн тухай хууль, 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Засгийн газрын хяналтын тухай хууль зэрэг анхдагч хуулиудыг, 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Монгол Улсад 20 орчим жил хэрэгжсэн мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог татан буулгах (үүнтэй холбоотойгоор 100 гаруй хуульд өөрчлөлт оруулсан),² 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлаар нэмэх³ зэрэг зарчмыг шинжтэй өөрчлөлтүүд тухайлсан судалгаа шинжилгээгүйгээр, олон нийтийн хэлэлцүүлэггүйгээр батлагдаж байв.

Иймээс 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр⁴ ХТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.5-д “*[тухайн жилийн улсын төсөв, төсвийн тодотгол]-ийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана*” гэх заалт нэмсэн.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл нь ХТХ-ийн тус нэмэлт, өөрчлөлтөөс хойших анхны улсын төсвийн төсөл бөгөөд энэ оны төсвийн тухай хуулийг дагалдуулан хоёр хуулийн нэмэлт, өөрчлөлт, УИХ-ын хоёр тогтоолын төслийг тус тус өргөн мэдүүлсэн нь сүүлийн зургаан жилийн хугацаан дахь хамгийн цөөн тооны хуулийг дагалдуулан өргөн мэдүүлсэн тохиолдол юм.

Энэхүү дүн шинжилгээгээр 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн бүрдэл нь ХТХ болон Төсвийн тухай хуульд нийцсэн эсэх, дагалдуулан өргөн мэдүүлсэн 2 хууль, УИХ-ын 2 тогтоолын төсөл нь ХТХ-ийн 29.5-д заасан шаардлагад нийцсэн эсэхийг тус тус дүгнэв.

² Нээлттэй Нийгэм Форум, “Дагалдах хууль, түүнд тавигдах шаардлага: Төсвийн тухай хуулийн дагалдах хуулиудад хийсэн дүн шинжилгээ”, ННФ Бодлогын асуудал Дугаар 40, 10 дахь тал, https://forum.mn/uploads/users/3092/files/OSF_Bodlogiin%20asuudal_40.pdf

³ Нээлттэй Нийгэм Форум, “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, өргөн барих зохицуулалтын дүн шинжилгээ”, ННФ Бодлогын асуудал Дугаар 38, 10- дахь тал, [Bodlogiin asuudal_38-Dagaldah-huuli.pdf](https://forum.mn/uploads/users/3092/files/OSF_Bodlogiin%20asuudal_38-Dagaldah-huuli.pdf)

⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17432175037602&showType=1>

2. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДУУЛАН ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Монгол Улсын Засгийн газар (ЗГ)-аас 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурал (УИХ)-ын даргад өргөн мэдүүлсэн⁵ бөгөөд тус хуулийн төслийг дагалдуулан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (НӨАТтХ)-д өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль (ТХХТтХ)-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэсэн хоёр хуулийн төсөл, Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай гэсэн УИХ-ын хоёр тогтоолын төслийг тус тус өргөн мэдүүлжээ.⁶

2026 оны төсвийн тухай хуулийн төслийн бүрдэл ба түүнд тавигдах шаардлага

ЗГ-аас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн тухай хууль нь дараах баримт бичгийн бүрдэлтэй байна.⁷ Үүнд:

1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн үзэл баримтлал;
2. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн танилцуулга (товч хувилбартай);
3. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт - Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт;
4. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт - Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалт;
5. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Хууль тогтоомжийн төслийг санаачлагч нь УИХ-д хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх үедээ баримт бичгийн хувьд ХТтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1-т заасан бүрдүүлбэрийн шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд эдгээр баримт бичгийн агуулгын шаардлагыг ХТтХ болон ЗГ-аас баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан. Түүнчлэн улсын төсвийн төслийн танилцуулгад тавигдах шаардлагыг Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн

⁵ Монгол Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас, “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг өргөн мэдүүлээ”, 2025 оны 9 сарын 1-ний өдөр, <https://www.parliament.mn/pn/75598/>

⁶ 2025 оны 9 сарын 1-ний өдөр УИХ-д өргөн барьсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл, <https://d.parliament.mn/tusul/e3da4090-62dd-4945-99da-eabb5e0cfb09>

⁷ Монгол Улсын Их Хурлын цахим систем (D-parliament), Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл, Сүүлд хандсан: 2025.9.28, МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

32.2-т нарийвчлан тусгасан. Иймд 2026 оны төсвийн тухай хуулийн бүрдүүлбэрт хамаарах баримт бичгүүд нь тус шаардлагуудыг хангасан эсэхийг дор дүгнэв.

Хүснэгт 1. 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн бүрдүүлбэр холбогдох шаардлагад нийцсэн эсэх талаарх дүгнэлт

Үзэл баримтлал	Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал нь ХТТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 2-4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байх ёстой. 2026 оны төсвийн тухай хуулийн үзэл баримтлалд тус хуулийн (i) үндэслэл, шаардлага, (ii) зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, (iii) үүсэх үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний санал, (iv) бусад хууль тогтоомжийн уялдааны талаар тусгасан байх боловч дагалдуулан өргөн мэдүүлж буй 2 хуулийн төсөл, УИХ-ын 2 тогтоолын төслийн хэрэгцээ, шаардлага, үр дагаврын талаар үзэл баримтлалд дурдаагүй.
Танилцуулга	Тухайн жилийн төсвийн тухай хуулийн танилцуулга нь Төсвийн тухай хуулийн 32.2-т заасан шаардлагыг хангасан байх ёстой. 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл нь дэлгэрэнгүй болон товч танилцуулгатай байх бөгөөд дэлгэрэнгүй танилцуулга нь Төсвийн тухай хуулийн 32.2-т заасан шаардлагыг хангаж, жагсаасан 21 агуулгыг бүхэлд нь тусгажээ. Мөн тус танилцуулгад дагалдуулан өргөн мэдүүлсэн 2 хуулийн төсөл, УИХ-ын 2 тогтоолын төслийн 2026 оны улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар тусгасан байхаас гадна дагалдах хууль тогтоомжийн төсөл бүрийн эхэнд товч үндэслэлийг дурдсан танилцуулгыг хавсаргасан байна.
Олон нийтийн хэлэлцүүлэг	Төсвийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлд заасан төсвийн ил тод байдлын зарчим болон 281 дүгээр зүйлд заасны дагуу олон нийтийн оролцоог хуульд зааснаар хангах ёстой. 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа ЗГ анх удаа иргэдийн санал асуулгыг E-Mongolia системээр зохион байгуулж, нийт 188,016 иргэн (насанд хүрсэн иргэдийн 8.2 хувь) оролцсон нь Монгол Улсад төсөв боловсруулахад иргэдийн оролцоог хангахдаа анх удаа цахим систем ашигласан тохиолдол болжээ. ⁸ Мөн цахим санал хураалтаас гадна танхимаар нийт 1390 хүн, бусад хэлбэрээр (вэбсайт болон утсаар) 238,388 хүн нийт 239,788 хүн оролцсон байна. Энэхүү олон нийтийн санал асуулга нь боловсруулагдсан хуулийн төсөл дээр бус төсвийн зарлагын зориулалт дээр олон нийтийн саналыг авах агуулгаар бэлтгэсэн асуултад суурилж, үр дүнг танилцуулгад дурдсан байх ⁹ бөгөөд ийнхүү олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх явцад дагалдах хууль тогтоомжийн талаарх агуулга багтсан эсэх мэдээлэл байхгүй байв.

2026 оны төсвийн тухай хуулийн төслийн бүрдүүлбэр нь хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийн шаардлагыг дээрх байдлаар хангажээ. 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн баримт бичгүүдээс зөвхөн танилцуулгад л дагалдуулан өргөн мэдүүлсэн 2 хууль, УИХ-ын 2 тогтоолын төсөлтэй холбоотой агуулга байв.

⁸ Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга”, 163 дахь тал, <https://d.parliament.mn/tusul/e3da4090-62dd-4945-99da-eabb5e0cfb09>

⁹ Дээр дурдсан, 165 дахь тал.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Тус хуульд заалтыг өөрчлөн найруулах шинжтэй 1 өөрчлөлтийг тусгасан бөгөөд үүгээр албан татвар төлөгчийн төлсөн албан татвараас буцаан олгох хувь хэмжээнд дараах өөрчлөлтийг оруулахаар байна.

Хүснэгт 2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн өөрчлөлтөөр хийгдэх гол зохицуулалт

Хугацаа	НӨАТ-ын буцаан олголтын хувь
2026 оны татварын жилд	- Сарын 1,000,000 хүртэлх төгрөгийн худалдан авалтад төлсөн татварын 50 хувийг, - Сарын 1,000,001 төгрөгөөс дээш худалдан авалтад төлсөн татварын 20 хувийг;
2027 оны татварын жилээс	- Сарын 0-500,000 хүртэлх төгрөгийн худалдан авалтад төлсөн татварын 100 хувийг, - Сарын 500,001-1,000,000 хүртэлх төгрөгийн худалдан авалтад төлсөн татварын 50 хувийг, - Сарын 1,000,001 төгрөгөөс дээш худалдан авалтад төлсөн татварын 20 хувийг;

Жил бүрийн улсын төсвийг батлахдаа дагалдуулан татварын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хандлага нийтлэг ажиглагддаг. Тодруулбал, 2021,¹⁰ 2022,¹¹ 2023,¹² 2024,¹³ 2025¹⁴ онуудад буюу сүүлийн таван жилийн хугацаанд тухайн жилийн төсвийн хуультай хамт татварын хуулиудад өөрчлөлт оруулж байв. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан өргөн мэдүүлсэн

¹⁰ Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хамт баталсан. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 он, №47 /1149/, <https://www.parliament.mn/nп/12522/>

¹¹ 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуультай хамт Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсан. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2021 он, №19 /1217/, <https://www.parliament.mn/nп/17656/>

¹² Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, Гаалийн албан татвараас хөнгөлөх тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хамт баталсан. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2022 он, №47 /1245/, <https://www.parliament.mn/nп/19096/>

¹³ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хамт баталсан. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2023 он, №45 /1293/, <https://www.parliament.mn/nп/51442/>

¹⁴ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хамт баталсан. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2024 он, №48 (1344), <https://www.parliament.mn/nп/63645/>

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анх 3Г-ийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын хууль тогтоомжийг шинэчилж, боловсронгуй болгохоор заасны дагуу Сангийн яамнаас Татварын ерөнхий хууль (ТЕХ), Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт НӨАТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл хэмээн боловсруулан олон нийтэд нээлттэй байршуулан санал авч байжээ. Эдгээр хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлэн болсон хэмээн Сангийн яамнаас мэдээлж байв.¹⁵ Гэвч тус татварын багц хуулиудыг УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө НӨАТХ-д өөрчлөлт оруулах хуулийг тусад нь 2026 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан өргөн мэдүүлжээ. Иймд тус хууль нь ХТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.5-д заасан “... төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана” гэх шаардлагыг хангасан байх учиртай.

2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга болон НӨАТХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгад төсөвт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тодорхойлжээ.

“Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, өрхийн хэрэглээндээ төлдөг татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалж, орлогын тэгш бус байдал буурч, татварын хамрагдалт нэмэгдэх ач холбогдолтой бөгөөд... нийт иргэдийн 75 хүртэл хувь нь нэмэгдсэн өртгийн албан татвараас 50-100 хувь хөнгөлөгдөх ба энэ нь 2026 оны төсөвт 375 орчим тэрбум төгрөгөөр нөлөөлөхөөр байна.”¹⁶

Өмнөх жилүүдэд тухайн жилийн төсвийн тухай хуулийг дагалдуулан баталж байсан татварын хуулиудтай харьцуулахад 2026 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан өргөн мэдүүлсэн НӨАТХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь улсын төсөвт хэрхэн нөлөөлөх тооцооллыг буюу төсөвт төвлөрөх татварын орлого буурах дүнг тодорхой тусгаснаараа онцлог юм.

Иймд НӨАТХ-д өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь ХТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.5-д заасан агуулгын болон 29.3-т заасан хэлбэрийн шаардлагыг тус тус хангаж байх бөгөөд ТЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь, хэмжээ болон татварын суурийг бууруулахтай

¹⁵ Сангийн яамны албан ёсны цахим хуудас, “Татварын багц хуулийн шинэчлэлийг боловсруулан УИХ-д өргөн барихад бэлэн боллоо” мэдээ, 2025.6.4, Сүүлд хандсан: 2025.10.2, Татварын багц хуулийн шинэчлэлийг боловсруулан УИХ-д өргөн барихад бэлэн боллоо. - САНГИЙН ЯАМ

¹⁶ Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн танилцуулга”, 153 дахь тал, Тус хуулийг дагалдуулан өргөн мэдүүлсэн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга”, 2 дахь тал, <https://d.parliament.mn/tusul/e3da4090-62dd-4945-99da-eabb5e0cfb09>

холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна” гэсэнтэй НӨАТ-аас хөнгөлөх хувийг өөрчилж буйгаараа мөн нийцэж байна.

Гэвч татварын хууль тогтоомжийг ийнхүү улсын төсвийн тухай хуулийг дагалдуулан батлахад дээр дурдсан шаардлагуудаас өмнө зарчмын болоод хууль тогтоомжийн тогтолцооны шаардлага мөн байх ёстой эсэх асуудал хөндөгдсөөр ирсэн. Тодруулбал, албан татвар нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар УИХ-ын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудал¹⁷ бөгөөд татвар нь зайлшгүй, тодорхой, шударга, үр ашигтай байх зарчмын дагуу тусдаа хэлэлцэгдэж, татварын хувь, хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийг өөрчилж, суурийг бууруулахдаа үндэслэл бүхий тооцоо, судалгааг ямагт гүйцэтгэж байх ёстой. Гэвч ийнхүү төсвийн хуулийг дагалдуулж буй тохиолдолд холбогдох судалгаагүйгээр батлагдсаар иржээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Тус хуульд зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах шинжтэй 9; нэр томьёо, үг хэллэгийг өөрчлөх, нэмэх, хасах шинжтэй 25; 4 хэсэг нэмэх; 1 хэсгийг хүчингүй болгох агуулга бүхий хуулийн төслийг боловсруулжээ. Хуулийн төслийн гол өөрчлөлтүүдийг дор хураангуйлав (Дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос үзнэ үү).

Хүснэгт 3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд туссан гол өөрчлөлт

Ерөнхий утга	Өөрчлөлтийн агуулга
Аймаг, нийслэлийн хэрэгжүүлэх түншлэлийн төсөлтэй холбоотой	Нийслэл болон улсын төсвөөс сүүлийн 3 жил дараалан санхүүгийн дэмжлэг аваагүй, эсхүл 100,000 ба түүнээс дээш хүн амтай аймаг л тодорхой салбарт түншлэлийн төслийг хэрэгжүүлэх боломжтой байсныг, Бүх аймаг болон нийслэл түншлэлийн төсөл хэрэгжүүлж болохоор;
	Аймаг, нийслэл зөвхөн тодорхой салбарт түншлэлийн төсөл хэрэгжүүлэх боломжтой байсныг, Аймаг, нийслэл бүх төрлийн салбарт түншлэлийн төсөл хэрэгжүүлж болохоор;

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:” гээд 25.1.7-д “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;” гэж заасан.

Ерөнхий утга	Өөрчлөлтийн агуулга
Төрийн үйлчилгээ үзүүлэх түншлэлийн төсөлтэй холбоотой	Нийтийн зориулалттай дэд бүтцийн төсөл эсхүл төрийн үйлчилгээний салбарын төсөл эсэхээс үл хамааран ТЭЗҮ болон бусад судалгаа хийгдсэн байх шаардлага тавьдаг байсныг, Төрийн үйлчилгээ үзүүлэх төслийн хувьд ТЭЗҮ шаардахгүй бөгөөд мөнгөний үнэ цэнийн шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээг хийхгүй байж болохоор;
Хувийн хэвшлийн түншлэгч сонгон шалгаруулахтай холбоотой	Хувийн хэвшлийн түншлэгч сонгон шалгаруулалтыг урьдчилсан болон уралдаант гэх хоёр үе шаттай байсныг, Сонгон шалгаруулалтын баримт бичигт тулгуурлан нэг үе шаттай сонгон шалгаруулахаар;
Процесс болон түншлэлийн төсөлд тавигдах шаардлага	Түншлэлийн төсөл шалгаруулахтай холбоотой үйл ажиллагааг цахимаар зохион байгуулахаар; Түншлэлийн төсөл нь хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, бүсчилсэн хөгжлийн бодлого болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх;
Бүрэн эрхтэй холбоотой	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүх төрлийн түншлэлийн төсөлд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгодог байсныг; Зардлыг нь хэрэглэгчийн төлбөр, хураамж болон төслийн орлогоор санхүүжүүлэх түншлэлийн төсөлд зөвхөн санал дүгнэлт өгөх, харин түншлэлийн төслийн зардлын улсын төсвөөс бүрэн болон хэсэгчлэн санхүүжүүлэх төслийн хувьд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгохоор; Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл өгөх, зөвшөөрөхгүй байх эрхтэй байсныг, Гэрээ байгуулах, гэрээний нэмэлт, өөрчлөлттэй холбоотой санал, дүгнэлтээ түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх болгох.

2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төсөвт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тодорхойлжээ.

“Монгол Улсыг 2026 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд ... улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 120 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгаснаас 42.5 хувь буюу 51 төсөл арга хэмжээг 2026 оны төсвийн төсөлд тусгасан бол 69 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байна. Тус хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татаж, түншлэлээр хэрэгжүүлэх, төсвийн дарамтыг бууруулах эерэг нөлөөтэй.”¹⁸

¹⁸ Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга”, 154 дэх тал, <https://d.parliament.mn/tusul/e3da4090-62dd-4945-99da-eabb5e0cfb09>

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад дээр дурдсанчлан төр, хувийн хэвшлийн түншлэлийн процессыг илүү хялбарчилснаар түншлэл ихсэж төсвийн дарамт буурах эерэг нөлөөтэй гэдгээс өөрөөр ХТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.5-д заасан Монгол Улсын 2026 оны төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөллийн талаар болон бусад нарийвчилсан тооцоо, судалгаа тусгаагүй байв.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дэх түншлэлийн төсөл хэрэгжүүлэгч болон түншлэлийн төсөлд тавигдах шаардлагыг хялбарчлах, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үе шатыг цөөрүүлэх зохицуулалтууд нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн нөхцөлийг дээрдүүлэх, процессын саад бэрхшээлийг бууруулахад чиглэсэн (зорилготой) байх боловч нөгөө талаараа төрийн үйлчилгээний түншлэлийн төсөлд ТЭЗҮ болон мөнгөний үнэ цэнийн шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээг хийхгүй байж болох; бүх аймаг, нийслэл түншлэлийн төсөл хэрэгжүүлэх боломжтой болж эрх хэмжээ нэмэгдүүлэх зэрэг чухал өөрчлөлтүүдийг аливаа судалгаа, шинжилгээ, харьцуулалтгүйгээр оруулахаар тусгажээ. Ингэснээр чанаргүй түншлэлийн төслүүдийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байж болох юм.

Түүнчлэн, Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлтэд уг хуулийн төслөөр түншлэлийн төслийг сонгон шалгаруулах үе шатыг багасгаж, сонгон шалгаруулах хугацааг 3-4 сараар хэмнэх боломжтой гэж үзсэн хэдий ч угтаа ЗГ-ын 2023 оны 404 дүгээр тогтоолоор баталсан Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журмын зохицуулалтын дагуу уг хугацааг сунгах боломж нь хэвээр байгаа талаар дурдсан.¹⁹ Энэ нь тус нэмэлт, өөрчлөлтийг төсвийн тухай хууль дагалдуулан ХТХ-д заасан тооцоо, судалгаагүйгээр боловсруулснаар тухайн харилцаа, асуудлыг сууриар нь бүрэн зохицуулж чадаагүй бөгөөд зорилгодоо хүрэх чадамжийг бууруулсан болохыг илтгэнэ.

Иймд, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь ХТХ-ийн 29.5-д заасан шаардлагыг хэлбэрийн төдий хангасан байх бөгөөд судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх суурь зарчим хангагдаагүй байна.

¹⁹ Төрийн аудит, “Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлт”, 2025 оны 9 дүгээр сар, 16 дахь тал, <https://d.parliament.mn/tusul/b66241af-bd23-40f9-b209-ff4feb0986d0>

Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай УИХ-ын тогтоолын төсөл

Тус тогтоолын төсөлд 2026 онд 561.2 тэрбум төгрөг хүртэлх дотоод үнэт цаас, 1 тэрбум ам.доллар хүртэлх гадаад үнэт цаас гаргах бүрэн эрхийг ЗГ-т олгохоор тусгажээ. ЗГ-аас жил бүрийн улсын төсвийн тухай хуультай хамт үнэт цаас гаргах эрх олгох тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлдэг. Тухайлбал, 2022, 2023, 2025 онуудад ЗГ-т үнэт цаас гаргах эрх олгосон тогтоолыг баталж байв. Энэ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 8 дугаар зүйлийн 8.1.2-т тус тус зааснаар тухайн төсвийн жилд ЗГ-ын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг төсвийн хамт өргөн мэдүүлж, УИХ-аас батлахаар заасантай нийцэж байна.

2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад ЗГ-ын үнэт цаас гаргах эрх олгох тухай УИХ-ын тогтоолын төслийн төсөвт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон.

“Засгийн газраас 2020 онд гаргасан “Номад” бондын 174.3 сая ам.доллар буюу 656.6 тэрбум төгрөгийн төлбөр 2026 оны 4 сарын 7-ны өдөр төлөгдөх хуваарьтай байгаа бөгөөд 2026-2028 оны хооронд нийт 1,130.1 сая ам.долларын төлбөр хугацаа тулсан байна. Энэ нь төрийн сангийн мөнгөн хөрөнгө болон гадаад валютын албан нөөц, төсөв, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах эрсдэлтэй байна. Дээрх үндэслэлүүдийг харгалзан 2026 онд 1 тэрбум ам.доллар хүртэлх ЗГГҮЦ-ыг, 562.2 тэрбум төгрөг хүртэлх ЗГДҮЦ-ыг арилжаалахаар УИХ-ын тогтоолын төсөлд тусгалаа.”²⁰

2026 оны төсвийн тухай хуульд ЗГ-ын тус онд шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг (i) зээллэг, (ii) өрийн баталгаа хэмээн ялгаатай тусгажээ. Үүнийг задлан үзвэл, тус хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.1-т зааснаар Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2 болон 12.1.3-т заасан зориулалтаар хийх дотоод зээллэгийн дээд хэмжээг 562.2 тэрбум төгрөг хүртэл, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 1.5 их наяд төгрөг хүртэл гэж зээллэгийн дээд хэмжээг тус тус тогтоосон бол, хуулийн төслийн 12 дугаар зүйлд ЗГ-ын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ 2026 оны төсвийн жилд 3.59 их наяд төгрөг байхаар өрийн баталгааны дээд хэмжээг заасан. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай УИХ-ын тогтоолын төсөл нь 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн дотоод зээллэгийн дээд хэмжээ болон ЗГ-ын гаргах өрийн баталгааны дээд хэмжээнд тус тус нийцсэн байна.

²⁰ Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн танилцуулга”, 154 дэх тал, <https://d.parliament.mn/tusul/e3da4090-62dd-4945-99da-eabb5e0cfb09>

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл

Тус тогтоолын төсөлд Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд гээд Тавантолгойн бүлэг ордын ашиглаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, орд ашиглалтыг сайжруулах талаар хөрөнгө оруулагч хуулийн этгээдүүдтэй хууль тогтоомжийн дагуу хэлцэл хийх агуулгыг тусгажээ.

2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад тус УИХ-ын тогтоолын төслийн төсөвт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон.

“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тус Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.”²¹

““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн экспортыг нэмэгдүүлэх хүрээнд биржийн томоохон дүнтэй арилжааг зохион байгуулах нь зүйтэй. Тухайлбал, 1.0 тэрбум ам.долларын үнийн дүнтэй 3-5 удаагийн нүүрсний том арилжааг амжилттай зохион байгуулсан тохиолдолд дэнчин болон эхний төлбөрийн орлогоор 250-350 орчим тэрбум ам.долларыг Монгол Улсад татан төвлөрүүлэх боломжтой байна.”²²

Тус тогтоолын төслийн агуулга болон 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон байдлаас үзвэл тус тогтоол нь таамагласан шинжтэй, хэрэгжих боломжтой эсэх нь эргэлзээтэй ерөнхий асуудлыг тусгасан бөгөөд үүнийг Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлтэд ХТТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.5-д заасантай нийцүүлээгүй, 2026 оны төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг тодорхой тусгаагүй, мөн ХТТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт буюу шийдвэрлэх асуудлыг энгийн ойлгомжтой байдлаар томъёолж бичих шаардлагыг мөн хангаагүй талаар дүгнэжээ.²³

Иймд тус тогтоолын төсөл нь ХТТХ-д заасан төсвийн дагалдах хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүйгээс гадна УИХ-ын тогтоолын төслийн үндэслэл, шаардлагыг тодорхой заасан байх²⁴ шаардлагыг ч хангаагүй байна.

²¹ Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн танилцуулга”, 155 дахь тал, <https://d.parliament.mn/tusul/e3da4090-62dd-4945-99da-eabb5e0cfb09>

²² Монгол Улсын Засгийн газар, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулга”, 155 дахь тал, <https://d.parliament.mn/tusul/e3da4090-62dd-4945-99da-eabb5e0cfb09>

²³ Төрийн аудит, “Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлт”, 2025 оны 9 дүгээр сар, 16 дахь тал, <https://d.parliament.mn/tusul/b66241af-bd23-40f9-b209-ff4feb0986d0>

²⁴ Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3.Тогтоолын төслийн тэмдэглэх хэсэгт уг тогтоол гарах болсон үндэслэл, шаардлага, эсхүл хуулийн заалтыг үндэслэсэн байна.

3. СУУРЬ АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХООР ОРОЛДОХ НЬ: ДАГАЛДАХ ХУУЛЬ ТОГТООМЖ БА ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ

Хэдийгээр тухайн жилийн төсөв батлах хуулийг дагалдуулан зөвхөн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийг батлах хязгаарлалт тогтоож, энэ нь статистикийн хувьд төсвийн тухай хуулийг дагалдуулан өргөн мэдүүлэх тогтоомжийн тоог бууруулсан байх боловч дагалдуулан өргөн барих хууль тогтоомжид судалгаа шинжилгээ хийхгүй (тухайн жилийн төсвийн тухай хуулийн танилцуулгад л товч дурдах замаар) байх хууль зүйн боломж хэвээр үлдсэн.

Хүснэгт 4. Хууль тогтоомжийн тухай хууль дахь дагалдах хууль тогтоомж болон багц хууль тогтоомжийн зохицуулалт, тэдгээрийг тайлбарлан хэрэглэх боломж

	Дагалдах хууль тогтоомж Dependent (Accompanying) Law	Хамт өргөн мэдүүлэх хууль тогтоомж Law Package
ХТтХ-ийн холбогдох зохицуулалт	29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага; 29.3. Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна. ²⁵	14 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулах; 14.4. Хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдүүлж болно. ²⁶ 14.5. ... төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болно.
Хэлбэрийн ангилал (хуулийн төслийн төрлөөр)	1. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл; 2. Хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.	1. Анхдагч хуулийн төсөл; 2. Шинэчилсэн найруулгын төсөл; 3. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл; 4. Хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.

²⁵ 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.10-т “шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх” гэсэн заалт байсан бөгөөд ХТтХ-иар дагалдах хууль гэдэгт зөвхөн (i) нэмэлт, өөрчлөлт оруулах болон (ii) хууль хүчингүй болсонд тооцох хуулийг хамруулж харин (i) анхдагч хууль, (ii) шинэчилсэн найруулгын төслийг бусад хуулийн төслийг дагалдуулан өргөн мэдүүлэхгүй байх агуулгыг анхнаасаа тусгаж байжээ. Харин үүнийг 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар үгчлэн тодорхой болгож ХТтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно” гэсэн заалт нэмжээ.

²⁶ 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4-т зааснаар багц хууль буюу хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэхийг хуулийн төслийн нэг төрөл болгон хуульчилан байсан. Гэхдээ энэ нь хуулийн төслийн бие даасан төрөл гэхээсээ илүү практик шаардлагаар хэд хэдэн хуулийн төслийг хамтад нь өргөн мэдүүлэх агуулгатай тул 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр хуулийн төслийн төрлөөс багц хууль гэх ойлголтыг хасаж, харин 14 дүгээр зүйлд хамт өргөн мэдүүлэх гэх агуулгаар хуульчилсан.

Агуулгаар ангилах нь буюу шинжийг тодорхойлохоор оролдох нь	ХТтХ-ийн 29.3 дахь хэсгийг “шаардлагатай тохиолдолд” гэдгийг дараах байдлаар тайлбарлах боломжтой. Үүнд: - Хуулийн төсөл, түүний зохицуулалтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй өөр хуулийг өөрчлөх, нийцүүлэх шаардлагатай; бөгөөд - Тухайн өөрчлөлт нь бие даасан агуулгатай бус байх. Тухайлбал, аливаа хууль батлах тохиолдолд түүний санкцыг Зөрчлийн тухай хуульд оруулах, хуулийн төслийг батлах тохиолдолд тухайн харилцааг өмнө зохицуулж байсан хуулийг хүчингүй болгох, нэг хуулийн нэр томъёог өөрчлөх тохиолдолд тухайн нэр томъёо бүхий бусад хуульд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг дагалдах хуульд хамруулах боломжтой.	ХТтХ-ийн 14.4 дахь хэсэг дэх “хэд хэдэн хуулийн төсөл” гэдэг нь уг багцад хамаарах хуулийн төслүүд нь бие даасан шинжтэй өөрчлөлтүүдийг агуулсан байх бөгөөд хэрэгцээ шаардлагын тандан судалгаа эсхүл хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд суурилан тэдгээрийн агуулгыг нэг үзэл баримтлалаар эсхүл тус тусдаа үзэл баримтлалаар тогтоох боломжтой. - Тодорхой үндэслэлээр хэд хэдэн хуулийн төслийг хамт өргөн мэдүүлж байгаа; бөгөөд - Хамт өргөн мэдүүлж байгаа төслүүд нь дагалдах хууль тогтоомжид хамаарахгүй байх.
Судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг хангахтай холбоотой санал	Дагалдаж буй хуулиасаа хамааралтай учир тухайн гол хуулийнхаа судалгаа шинжилгээний хүрээнд бүрэн хамаарна. Иймд тусдаа бие даасан судалгаа шинжилгээ хийх шаардлагагүй.	Тус бүр бие даасан хууль тогтоомжууд тул ХТтХ-д заасан судалгаа шинжилгээг, хэрэв ХТтХ-ийн 12.2-т жагсаасан хууль тогтоомж бол холбогдох хуульд тусгайлан заасан шаардлагад нийцүүлэн судалгаа шинжилгээг тус тусад нь хийх шаардлагатай.

Дагалдах хууль тогтоомж болон хамт өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн агуулгын ялгааг тодорхойлж, тавигдах шаардлагуудыг тогтоох, судалгаа шинжилгээ хийх эсэх, олон нийтээр хэлэлцүүлэх эсэх асуудлыг ХТтХ-д тодорхой зохицуулах нь зөвхөн төсвийн тухай хуулиар хязгаарлагдахгүйгээр асуудлыг сууриар нь шийдэхэд ач холбогдолтой байх боломжтой гэж судалгааны баг үзэв.

Тодорхой хууль тогтоомж батлагдах, өөрчлөгдөх, хүчингүй болохтой хамааралтай буюу уялдан өөр хуульд өөрчлөлт орох шаардлагатай нөхцөл байдалд “дагалдах хууль” гэх, харин хамт батлагдсанаар эрх зүйн үр нөлөө нь бүрэн хэрэгжих нөхцөл байдлыг “багц хууль” буюу хэд хэдэн хууль тогтоомжийг хамт өргөн мэдүүлэх гэх ойлголтоор тус тус илэрхийлэх боломжтой.

4. ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд улсын төсөв батлах тухай хуулийг дагалдуулан төсөвтэй хамааралгүй, зарчмын шинжтэй өөрчлөлт агуулсан, түүнчлэн анхдагч хуулиудыг ч тухайлсан судалгаа шинжилгээгүйгээр батлах явдал гарч, шүүмжлэл дагуулсаар иржээ. Үүнтэй холбоотойгоор 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тухайн жилийн улсын төсвийн төслийг дагалдуулан зөвхөн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх агуулга бүхий өөрчлөлт орсон. Монгол Улсын Засгийн Газраас 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан 2 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Улсын Их Хурлын 2 тогтоолын төслийг тус тус өргөн мэдүүлсэн нь сүүлийн зургаан жил дэх хамгийн цөөн хууль тогтоомж дагалдуулан өргөн мэдүүлж буй тохиолдолд бөгөөд эдгээр нь төсөвт хэрхэн нөлөөлөх талаар 2026 оны төсвийн тухай хуулийн танилцуулгад тодорхой хэмжээнд дурдсан байв. Үүнийг олон нийт, судлаачдын шүүмжлэл болон Хууль тогтоомжийн тухай хуулийн дээр дурдсан өөрчлөлттэй холбоотой гэж үзэх боломжтой. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төслүүд нь:

1. **Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл** нь хуулийн төслийн хэлбэрийн хувьд өөрчлөлт оруулах тухай хууль учир ХТтХ-ын 29 дүгээр зүйлийн 29.3-т заасан дагалдах хуулийн хэлбэрийн шаардлагад нийцсэн, түүнчлэн 2026 оны төсвийн зарлагад нөлөө үзүүлэхээр байх тул ХТтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.5-д заасан агуулгын шаардлагад нийцжээ. Гэвч албан татвар нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарахаас гадна шударга, үр ашигтай байх зарчмын хүрээнд татварын хувь, хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийн өөрчлөлт нь үндэслэл бүхий тооцоо, судалгаанд ямагт үндэслэх учиртай. Гэвч ийнхүү төсвийн хуулийг дагалдуулж буй тохиолдолд холбогдох судалгаагүйгээр батлагдаж байна. Иймд цаашид татварын хууль тогтоомжийг тухайн жилийн улсын төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлэх тохиолдолд судалгаа, тооцоог гүйцэтгүүлж, хуулийн өөрчлөлтийг судалгаанд үндэслэхийг хууль санаачлагч болон хууль тогтоогчийн зүгээс анхаарах нь зүйтэй.
2. **Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл** нь хуулийн төслийн хэлбэрийн хувьд ХТтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.3-т заасан шаардлагад нийцсэн боловч ХТтХ-ийн 29.5-д заасан шаардлагыг хэлбэрийн төдий хангасан буюу төсвийн орлого, зарлага, тэнцэлд хэрхэн нөлөөлөх талаар нарийн тодорхойлоогүй зөвхөн эерэг нөлөөтэй гэж ерөнхийлөн тодорхойлсон байв. Тус хуулийн төслийн зохицуулалтууд нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн нөхцөлийг дээрдүүлэх, процессын саад бэрхшээлийг бууруулахад чиглэсэн

(зорилготой) байх боловч төрийн үйлчилгээний түншлэлийн төсөлд техник эдийн засгийн үнэлгээ болон бусад шинжилгээ хийхгүй байж болох; бүх аймаг, нийслэл түншлэлийн төсөл хэрэгжүүлэх боломжтой болж эрх хэмжээ нь нэмэгдэх зэрэг чухал өөрчлөлтүүдийг аливаа судалгаа, шинжилгээ, харьцуулалтгүйгээр оруулахаар тусгажээ.

3. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь холбогдох хуульд нийцсэн байна.
4. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцоолол нь тодорхойгүйн зэрэгцээ ХТтХ-ийн 36 дугаар зүйлийн 36.4-т заасан шийдвэрлэх асуудлыг энгийн ойлгомжтой байдлаар томъёолж бичих, 36.3-т заасан Улсын Их Хурлын тогтоолын төслийн үндэслэл, шаардлагыг тодорхой заасан байх шаардлагуудыг ч хангаагүй байв.

Тухайн жилийн төсвийн тухай хуулийг дагалдуулан өргөн мэдүүлэх хуульд хязгаар тогтоосон ХТтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг нь тодорхой хэмжээнд эерэг нөлөөтэй байх боловч хууль тогтоогчийн зүгээс төсвийн тухай хуулийг дагалдуулан өргөн мэдүүлсэн хууль тогтоомж нь төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд нөлөөтэй эсэх, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгасан эсэхэд хяналт тавьж, шаардлага хангаагүй, бие даасан судалгаа шинжилгээ шаардлагатай байгаа тохиолдолд хуулийн төслийг буцаах зэрэг байдлаар тус заалтын хэрэгжилтэд онцгой үүрэг гүйцэтгэхээр байна.

Түүнчлэн дагалдах хууль тогтоомж, хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжуудын хувьд ХТтХ-д заасан (i) хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ; (ii) зардлын тооцоо; (iii) үр нөлөөний үнэлгээг тусдаа гүйцэтгэхгүй байх замаар тооцоо судалгаагүй хууль тогтоомжууд батлагдах хууль зүйн боломж хэвээр байгааг анхаарах нь зүйтэй. Дагалдах хууль тогтоомжийн шинж чанар нь тодорхой нэг хуулийг хэрэгжүүлэх, тухайн хуультай нийцсэн байх шаардлагаас урган гардаг тул тусдаа судалгаа шаардлагагүй, харин хамт өргөн мэдүүлэх хууль тогтоомжууд нь тусдаа хэд хэдэн хуулиудаас бүрдэх тул тус бүрдээ судалгаа шинжилгээ хийсэн байх учиртай. Иймд дагалдах хууль тогтоомж болон хамт өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн шинжийг тодорхойлох замаар уг асуудлыг шийдвэрлэх боломжийг нарийвчлан судлах нь ач холбогдолтой (Дүн шинжилгээний өмнөх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү).

Энэхүү дүн шинжилгээ нь төсвийн цаглабартай холбогдуулан төсвийн хэлэлцүүлгүүд хараахан өрнөж эхлээгүй байх үед цаг хугацааны хувьд харьцангуй богино хугацаанд хийгдэж байгаа тул судлаачдын зүгээс зөвлөмж боловсруулаагүй болно.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж (үсгийн дарааллаар)

Зөрчлийн тухай хууль, 2017 он
Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль
Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль
Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль
